



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/1125

Улаанбаатар хот

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2023 оны зорилт”-ын 2023 оны А/688 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт 3.“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ, 4.“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ гэсэн заалтыг өөрчилсүгэй.

2.Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ биелүүлж, орлого, үр дүнг нэмэгдүүлэн, авлага, өр төлбөрийг бууруулан, үйл ажиллагааны менежментийг сайжруулж ажиллахыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ (Ц.Баттөр), “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110204845



ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДЫН 2023 ОНЫ ЗОРИЛТ

№	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэрс	Нийт орлого			Нийт зардал			Ашиг, алдагдал			Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	Нийт хөрөнгө оруулалт
		2022 оны зорилт	2022 оны гүйцэтгэл	2023 оны зорилт	2022 оны зорилт	2022 оны гүйцэтгэл	2023 оны зорилт	2022 оны зорилт	2022 оны гүйцэтгэл	2023 оны зорилт		
3	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	42,737,132.7	53,379,636.8	59,316,356.1	48,468,243.70	50,710,492.90	69,222,421.70	(5,731,111.0)	1,669,143.9	(9,605,065.6)	1.1	3,510,000
4	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	17,370,529.7	21,007,725.6	23,721,476.3	21,524,112.9	19,184,771.0	31,307,394.84	(4,153,583.2)	1,822,954.6	(7,585,918.5)	1.3	1,095,200
Нийт дүн		60,107,662.4	74,387,362.4	83,037,832.4	69,992,356.6	82,017,887.7	100,529,816.54	(9,884,694.2)	3,492,098.5	(17,190,984.1)	2.4	4,605,200